



**Дашбалбар сумын ерөнхий
боловсролын сургуулийн 2023-2024
оны хичээлийн жилийн зорилго,
зорилтын тайлан**

2024.06.19



Алсын хараа:

Боловсролын үйлчилгээг хүүхдэд ээлтэй орчинд чанартай хүргэж нийгэмд бие даан амьдрах чадвартай иргэн төлөвшүүлнэ.

Эрхэм зорилго:

Эх хэл соёлоо эрхэмлэсэн, өөртөө итгэлтэй хүүхэд – Бидний ирээдүй

**БШУЯам нь 17 зорилго, зорилтыг
дэвшүүлсэн.**

**Дашбалбар сумын ЕБСургууль нь
зорилго, зорилт – 12 дэвшүүлсэн.**

Бүтэц орон тоо: 69 батлуулсан

❖ Удирдах ажилтан – 3

❖ Үндсэн багш – 31

Бага ангийн багш -10

Дунд, ахлах ангийн багш – 21

❖ Үндсэн ажилтан – 35

НТБ-ын багш – 1

Нийгмийн ажилтан -1

Дотуур байрын багш -2

Эмч – 1

Нягтлан -1

Нярав -1

Архив, бичиг хэрэг -1

Мэргэжлийн багшийн хангалт:

Энэ хичээлийн жилд 31 багш ажиллахаас бага, математик-мэдээллийн технологи, зураг зүй, технологи, физикийн мэргэжлийн багш дутагдалтай, үндсэн багш 29 ажиллаж, тэтгэврийн 3 багш ажиллуулсан.

Үүнээс:


❖ Мэргэжлийн багшийн хангалт – 92,8%

❖ Мэргэжлийн зэрэгтэй багш – 58,6%


Үүнээс: **Тэргүүлэх - 11**

Заах аргач зэрэгтэй багш - 6

БАГШ НАРЫН БОЛОВСРОЛЫН
ЗЭРЭГ



БАГШ НАРЫН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ




■ Заах аргач ■ Тэргүүлэх ■ Зэрэггүй багш


2024 онд	69	3	31	Бага ангийн багш-2, Англи хэл, Математик-мэдээллийн технологи, Физикийн багш
	Зураг зүй, технологийн багш, Сэтгэл зүйч, Хоол зүйч 3 орон тоо нэмэгдүүлсэн.			Дутагдалтай: багш- 5 /3/, ажилтан-2

Суралцагчдын тоо:

Хичээлийн жил	Нийт сурагчдын тоо	Бага	Суурь	Бүрэн дунд	Анги бүлэг	Бүлэг дүүргэлт	Дотуур байр
2023-2024	625	301	228	95	22	28,4	120



■ 2023-2024 хичээлийн жил



■ 2023-2024 хичээлийн жил

Дашбалбар сумын ЕБСургуулийн менежментийн загвар

Төрөөс баримтлах боловсролын бодлого

Бүх шатны сургалтын байгууллагын багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй хэрэгжүүлж, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, суралцагчийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах

Хүсч буй хүүхдийн дүр төрх:

Уншиж ойлгох, суралцахуйн суурь чадвартай, бүтээлч хандлагатай, хүнлэг, энэрэнгүй, эрүүл зөв дадалтай хүүхэд

Сургалтын үйл ажиллагаа

Орон нутаг:

- Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах
- Багш нарыг тогтвор шуурьшилтай ажиллахад бодлогоор дэмжих
- Сургалтын тохилог орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Суралцахуйн суурь чадвар сайжруулахад:

- Унших бичх, тооцоолох чадварыг ахиулна
- Хичээл бүрийн уншин ойлгох чадварыг шалгуур үзүүлэлтээр үр дүнг тооцох
- Уншсан номын тэмдэглэл хөтлүүлэх
- Судлагдахуун бүр нэгтгэн дүгнэх дадлага ажил хийх

Шинжлэх ухаанч, бүтээоч арга барил эзэмшүүлэх:

- Танин мэдэхгүйн түвшиний даалгавар гүйцэтгэх
- Интеграци, экскурс хичээлүүдийг төлөвлөн зохион байгуулах
- Багаар аэжиллах даалгавар гүйцэтгэх
- Нэгж хичээл бүрт задлан шинжлэх даалгавар оруулах

Хүүхдийн хөгжил, төлөвшил хамгааллыг дэмжин эцэг эх, олон нийттэй хамтран ажиллаж хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх:

-“Номтой өдөр” анги бүрт уншлагын цагийг номын сантай хамтран зохион байгуулж, улиралд 3 зохиол уншиж ярилцлага хийх

- “Сургууль – Бидэнд ээлтэй 2 дахь гэр минь” эцэг эхийн бүтээлч аян өрнүүлэх

- Судлагдахуун бүрээр хичээлийн дэг мөрдөж, багийн зохион байгуулалттай хичээл төлөвлөх

-“Багш бүр нэг дугуйлан” –аар хүүхдийн авьяасыг нээн илрүүлж, хөгжүүлэх

-“Хүрэх үйлчилгээ- Хүүхдийг дэмжинэ” АУБ бүр сурагчдын ар гэрт хүрч боловсролын зөвлөх үйлчилгээ үзүүлж хамтран ажиллах (Улирал бүр)

Сургуулийн зорилго:

Эх хэл соёлоо эрхэмлэсэн, өөртөө итгэлтэй хүүхэд - Бидний ирээдүй

Тэргүүлэх зорилтууд

1. Хичээл бүрийн ойлгон уншин чадвар сайжруулах
2. Шинжлэх ухаанч, бүтээлч арга барил эзэмшүүлэх
3. Хүүхдийн хөгжил, төлөвшил , хамгааллыг дэмжин эцэг эх, олон нийттэй хамтран ажиллаж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх
4. Хүүхэд бүрт “БИ ЖИЖҮҮР” хөтөлбөр
5. Багшийн заах арга, ур чадварыг ахиулан хөгжүүлж, сурлагын амжилтыг хичээл бүр ахиулах

Өмнөх жилийн асуудал

- ✓ Сурагчдын ярих, сонсох чадвар хангалтгүй байна\
- ✓ Сурлагын ахиц хөндлөнгийн үнэлгээгээр буурсан үзүүлэлттэй байна.
- ✓ Сурагчдын бусадтай харилцах, харилцаа хандлага хангалтгүй байна.

Үнэлгээний шалгуур

БГҮ-ний бичгийн шалгалтын уншин ойлгох, шинжлэх ухаанч чадварыг **5%** ахиулах
Үйл ажиллагааны гүйцэтгэл тус бүрд хагас жил тутамд үнэлгээ хийж дүгнэн, хамт олонд мэдээлэх, эцэг эхэд тайлагнах
Дугуйланд хамрагдсан сурагч, тэдний эцэг эхээс сэтгэл ханамжийн үнэлгээг улиралд тутамд авч, үр дүнг тооцон ажиллах
Сурагчдын мэдлэг, чадварын ахицын үнэлгээний сорилыг хагас жилд нэг удаа авч, үр дүнг тооцон **3-5%**-иар ахиулан ажиллах

Ёс зүйг эрхэмлэн, байгууллагын соёлыг дээдлэх

-Дүрэмт хувцасаа өмсөж хэвших (Багш сурагчид)

- Анги танхим, ажлын байрандаа эмх цэгцтэй цэвэр орчин бүрдүүлж ажиллах

-“Эелдэг инээмсэглэл ” мэндлэх хүндлэх ёсыг хэвшүүлэх

Хичээл бүрээр хөндлөнгийн үнэлгээг тогтмолжуулж, үр дүнг тооцох:

-Сар бүр хөндлөнгийн үнэлгээг тогтмолжуулж анализын мөрөөр ажиллах

- Улирлын эцэст тухайн бүлэг сэдвүүдээр сурсан мэдсэн зүйлийнхээ талаар бүх суралцагчид дүгнэн бичиж ярилцах (бүх ангид бүх судлагдахуунаар)

-Мини шалгалт (Судлагдахуун бүрээр улирал бүр 4-6 удаа)

-Хүүхэд бүрт “Эх оронч үзэл”-ийг төлөвшүүлэхэд ажилтан бүр үйл ажиллагаагаа чиглүүлэх:

- Монгол ахуй зан заншил улирлын онцлогтой мэндчилгээг хүүхэд бүрт хэвшүүлэх (Бүх судлагдахуунаар - АУБ үйл ажиллагаагаар)

-“ Би эх орны ирээдүй” сурагчдад эх оронч үзэл төлөвшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах (Бүх багш ажилчид улирал бүр, 2-3, 4-5, 6-7, 8-9, 10-11,12 ангиудад 6 багт хувааж чиглүүлнэ)

- “Миний гэр бүл- Эх орны ирээдүй” эцэг эх, багш ажилчдын чуулган зохион байгуулах

ЗОРИЛТ-1:

Боловсролын ерөнхий хуулийг суралцагч, эцэг эх асран хамгаалагч, багш ажилтанд таниулах, хэрэгжүүлэх



Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын хуулийг сурталчлах ажлыг 4 удаагийн үйл ажиллагаагаар хэрэгжүүлж давхардсан тоогоор 480 гаруй суралцагч, 120 гаруй багш ажилтан, 520 гаруй эцэг, эх асран хамгаалагч нарт хүргэсэн.

1-12 дугаар ангийн эцэг, эх асран хамгаалагч нарт Боловсролын ерөнхий хууль, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийг сурталчлан эцэг эхийн эрх, үүрэг сурагчийн эрх үүргийг танилцуулан ажиллав. Уг үйл ажиллагаанд давхардсан тоогоор 285 эцэг эх хамрагдаж мэдээлэлтэй танилцсан. Мөн ангиуд ангийн фасэбүүк групп, чат группэд буй эцэг эхчүүдэд боловсролын тухай хуулийг сурталчлан мэдээллийг хүргэсэн.

Дунд, ахлах ангийн суралцагчдын эцэг эх, асран хамгаалагчдын хүрээнд **“НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ”**-ийн өдөрлөгийг 2023-2024 оны хичээлийн жилийн үйл ажиллагаа болон Мэргэжилийн багш нар судлагдахуун бүрээр 8 өртөө болгон сургалт, мэдээллийг амжилттай зохион байгуулав. Өртөө сургалтад 12 бүлгийн давхардсан тоогоор 190 гаруй эцэг, эх, асран хамгаалагч нар хамрагдсан.



Багш нарын баярыг угтан **Мэргэжлийн зэрэгтэй багш** нар нь нийт 60 гаруй багш ажилчдаа өртөөчилсөн сургалтыг зохион байгуулсан бөгөөд уг үйл ажиллагаанд бага ангийн 2 багш, сургалтын менежер нар Н.Долгорсүрэн, бага ангийн багш Д.Борхүүхэн нар хамтран Боловсролын ерөнхий хуулийг сурталчлан таниулж өртөөчилсөн сургалт зохион байуулж тэдний мэдлэгийг kahoot программыг ашиглан үнэлж дүгнэв.

Бага ангийн эцэг эхийн өдөрлөгийг **“ЗӨВЛӨЕ, ХАМТАРЪЯ, ТУСАЛЪЯ”** сэдэвтэйгээр зохион байгуулж эцэг эхчүүд анги ангиараа хамтран сургалт мэдээлийн цагт хамрагдлаа. Сургалтад сургуулийн удирдлага сургуулийн ахмадын зөвлөл бага ангийн багш нар оролцож мэдээлэл өгч харилцан санал солилцлоо. Уг өдөрлөгөөр сургуулийн захирал боловсролын шинэчлэгдсэн хуулийг таниулан мэдээлэл өгөв. Бага ангийн эцэг эхчүүд 102 эцэг эхчүүд хамрагдсан байна. Өртөө тус бүрт идэвхтэн эцэг, эхийг тодруулан урамшуулав.




ЗОРИЛТ-2:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургалт үйл ажиллагаагаар ДЭМЖИХ

1-12 дугаар ангид хөгжлийн бэрхшээлтэй 9 суралцагчаас 7 сурагч нь өдрийн ангид танхимаар боловсрол эзэмшиж байгаа бөгөөд АУбагш нар нь хүүхэд бүрийн онцлогт тохирсон төлөвлөлт боловсруулан сурагч нэг бүртэй ганцаарчилсан хөтөлбөрөөр ахиц үр дүнг тооцож ажилласан. Багш бүр сурагчийг оношлон судалж хөгжлийн ялгаатай сургалтыг зохион байгуулж сар бүрийн эцэст ахицыг тооцон ажиллав.



- Бие эрхтэний саажилттай 5 сурагч
- Хавсарсан хэлбэрийн саажилттай 1 сурагч
- Оюун ухааны хөгжлийн бэрхшээлтэй 2 сурагч
- Харааны бэрхшээлтэй 1 сурагч

Бага ангийн 5-н анги удирдсан багшид нэмэгдэл хөлсийг журмын дагуу 2024 оны 01 дүгээр сараас олгож байна.



- Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдын ашиглах сугарлтын атериал
- Бага сургуулийн гарц тэмдэглэгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй нооль тохижуулах
- Давхар шатны гөгсөхөд бариул

**Бага
ангийн
дэмжих
төсөл**



Ганцаарчилсан ажиллах төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг хичээлийн жилд хэрэгжүүлж ажилласан:

- Бага боловсролын багш нар нь хэрэглэгдэхүүний зардлаар Хэл яриа, Танин мэдэхүй, Дүрслэх урлаг гэсэн 3 ном захиалан авч, даалгавруудыг ажиллуулсан
- 35 үсэг нүдлүүлэх, бичүүлэх, үелүүлэх
- 1-100 хүртэлх цифрийг ялгуулах, 4 үйлдлийн тоог бодуулах
- Ангидаа зааж буй буриад шүлэг, ерөөл магтаалаас өгч цээжлүүлэх
- Үлгэрийн ном хэрэглэгдэхүүнээр захиалан авч, уншуулах, зургийг зурах үйлийг хийлгэх
- Анги хамт олонд нь нийгэмших, найз нөхөдтэйгээ чөлөөтэй харьцаж, ярилцаж сургах, олон нийтийн үйл ажиллагаанд оролцуулсан
- Асуусан асуултад нэг үгээр хариулах, үгүй, тийм, толгой дохиу зэргээр харилцаанд оролцдог болгох
- Даалгавар багшийн заавраар гүйцэтгэж маш удаан хугацаанд хийж гүйцэтгэдэг нь багш тухайн сурагчтай заавал цаг гаргаж ажиллах шаардлагатай болж байсан.

ЗОРИЛТ-3:

Хүүхэд бүрийн онцлог ялгаатай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

"НЭЭЛТТЭЙ-СУРГУУЛЬ" үйл ажиллагааны хүрээнд ХҮН БОЛОХ БАГААСАА төслийн спортын багц, Жудо, Ширээний теннис, Волейбол, Үндэсний сурын дугуйлангийн сурагчдын үзүүлэх тоглолтыг тайлагнаж, Дугуйлангийн сурагчдын 3 видео бичлэг хийж, цахимд байршуулж бусдад түгээн дэлгэрүүлсэн.



<https://www.youtube.com/watch?v=tK2ypTboTHU>,
<https://www.youtube.com/watch?v=QZuk8rJnjFA>,
<https://www.youtube.com/watch?v=a0j5M2nCtJs>



Үр дүнд: Биеийн тамирын багш Х.Мөнгөнхуягийн дасгалжуулсан сурагчид УАШ жүдо бөхийн тэмцээнд мөнгө 1, хүрэл 1, С.Сайнбатын дасгалжуулсан сурагч, УАШ хөнгөн атлетик тэмцээнд мөнгөн мепаль тус тус хүртсэн амжилтыг үзүүлсэн.



Хүн болох багаасаа төсөл:

1. Гадаад хэл - 60-2 багш
2. Спорт -70 -3 багш
3. Авьяас – 90- 4 багш тус тус хичээлүүлж байна.



Хүн болох багаасаа төслийн хүрээнд Англи хэл дээр 6 дуу, 2 шүлэг, Орос хэл дээр 4 дуу 2 шүлэг цээжилсэн. Бид сургалтаа тоглоомын аргыг түлхүү ашиглаж дуу сурч сонсох, түүх, шүлэг унших, өөрийгөө танилцуулж харилцан ярих, дасгал даалгавар хийж, өөр хоорондоо өдөр дутмын энгийн өгүүлбэрээр харилцан ярьж хэрэглээ болгох чадваруудыг эзэмшүүлж Төслийн тайлант өдөрлөг 2023.11.28-ны өдөр зохион байгууллаа. Тус өдөрлөгт 98 хүүхэд оролцож сурсан дуу, өөрийгөө танилцуулаж, шүлэг уншиж, 123 эцэг эх үзэж танилцлаа. Төслийн багаас 2 сонин, 1 үйл ажиллагааны бичлэг, 80ш брошур, 15ш танилцуулга хийж аймгийн тамгийн газраас нэгдсэн “Хүүхэд бүр нэгт” хүн болох багаасаа төслийн тайланд түгээн дэлгэрүүлэлт хийсэн.

ЗОРИЛТ-4:

Математик, англи хэлний eduten 3-4 анги, Pearson хөтөлбөрийг 5-6 дугаар ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар, багшийн аргазүйд ахиц гаргах



МАТЕМАТИК-ЭДҮТЭН
3-4 дүгээр ангийн 4 бүлгийн 112
сурагч амжилттай суралцсан.

АНГЛИ ХЭЛ- PEARSON
5-6 дугаар ангийн 4 бүлгийн
128 сурагч амжилттай
суралцсан.

Цаашид анхаарах:

- Унших, сонсох даалгавар дээр ажиллах чадварыг 30% нэмэгдүүлэх
- Англи хэлний чадваруудыг алхам алхамаар хөгжүүлэх
- Даалгавар бүрийг хугацаанд гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэх

2023-2024оны хичээлийн жилд 3-4 дүгээр ангийн 4 бүлгийн нийт 112 сурагч Эдүтэн хөтөлбөрт хамрагдаж байна. Багш нар болон сургалтын менежерүүд 4 удаагийн цахим сургалтад хамрагдаж мэдээлэлтэй болсон ба сургуулийн сургагч багш Х.Булганцэцэг нь бусад багш нараа дагалдуулан сургаж хичээл сургалтыг амжилттай зохион байгуулсан. 4 дүгээр ангийн хүрээнд 3 нэгж хичээлийг амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд 1.Олон оронтой тоо, 2.Эерэг сөрөг тоо, 3.Өгөгдөлтэй ажиллах буюу диаграмм гэсэн хичээлүүдийг үзэж сурагчид цомоо аван ахицтай суралцаж байна.

5а,б ангийн 63 сурагч, баб ангийн 66 сурагчдад анги хэлний Pearson хөтөлбөрийг танхим, цахим хэлбэрээр хичээлийг зохион байгуулж байна. Ээлжит хичээлд багш дэлгэцээр даалгавр дагуулж хийлгүүлэх, сурагчид утсан дээрээ багшийг даган дасгал даалгавраа хийж гүйцэтгэдэг.

Сурагчид гэрт утсан дээрх даалгавр хийн дэвтэртээ тэмдэглэж авч байгаа нь тонгоруу сургалтын арга буюу бие даан суралцах аргад суралцаж байна. Мөн сурагчид хос хосоороо өдөр бүр дасгал даалгавраа хийж гүйцэтгэн тухайн өдөр хичээл даалгавраа хамгийн өндөр гүйцэтгэлтэй хийсэн талаар дүгнэж ярилцан урамшуулдаг. Сургуулийн нөхөн хангалтын зардлаас гадаад хэлний кабинетад ухаалаг дэлгэц, 20ш таблет өгсөн нь сурагчдын сурах таатай орчныг бүрдүүлж, багш нарын хичээлээ заах орчин нөхцөл бүрдсэн.

ЗОРИЛТ-5:

Нэгдмэл агуулга бүхий төсөлт ажлыг 1-12 ангид багаар хамтран гүйцэтгүүлж, улирал бүр үр дүнг тооцох

Сурагчдын хоцрогдлыг нөхөх арилгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсролын хүрээлэнгээс гаргасан бие даан ажиллах даалгавар 100 гаруй ажлын хуудас болон тест, мэдлэг чадвар сорих даалгавруудыг ажиллуулсан.

Мэргэжлийн 29 багш анги т бүрийн хоцрогдол арилгах зорилгоор улирал бүр гарааны үнэлгээг тодорхойлж, агуулга нөхөх төлөвлөгөө гарган ажилласан.

Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурын дагуу 87 даалгавар боловсруулан ахицыг тооцож ажилласан.

Сурагчдын түвшинг тогтоож агуулгыг нөхөхийн тулд 56 ялгаатай даалгаврын сан үүсгэн ажилласан.

Цахим, танхимын сургалтыг хослуулан 28 судлагдахууны агуулга нөхсөн.



Математикийн сургалтын амжилтыг ахиулах зорилготой:

- “Язгуур баг” математикийн олимпиадад Дорнод аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын
- “Улз сав нутгийн математикийн” 32-р олимпиад: Бүтэн зууны арвин түүхтэй Баяндун сумын сургуульд математикийн багш Ц.Батболдын нэрэмжит зохиогдсон энэхүү олимпиадад
- Математикийн стандарт бодлого олимпиадад
- Олон улсын логик пазл
- Кенгуру

Давхардсан тоогоор 110 гаруй сурагч оролцож, Алтан медаль 3, Мөнгөн медаль 6, хүрэл медаль 8, тусгай байр 11 сурагч орсон.


Төрөлжсөн олимпиадын амжилт:

1. Монголын түүхийн багш төрөлд 3 дугаар байр Б. Одонтүяа

ЗОРИЛТ-7:

Ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулан сургах, тэгш боломж олгох орчныг бүрдүүлж, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх

Сурагчдын түвшинг тогтоож агуулгыг нөхөхийн тулд 56 ялгаатай даалгаврын сан үүсгэн ажилласан.



Remark office OMR цахим системийг 2 дахь жилдээ ашиглаж байна.

Үр дүнд: Цахим системийг ашигласнаар багш нарын цагийг хэмнэж, богино хугацаанд олон материалыг уншуулдаг болсон. Шалгалтын материал бүрийн ард анализыг олон хувилбартай авдаг болсон. 12 дугаар ангийн ЭЕШ 17 сурагчийн бэлтгэл шалгалт монгол хэл, математик, хими, биологи, түүх, нийгмийн ухаан хичээлээр, гүйцэтгэлийн үнэлгээнд бэлтгэл хангах зорилгоор судлагдахцны хичээлүүдээр 6-11 дүгээр ангийн 290 сурагчдаас авч материалыг богино хугацаанд шалгаж, дүн шинжилгээ хийж байна.



Student	Date	Score	Status
101. Student Name	2023-09-13	85	Pass
102. Student Name	2023-09-13	78	Pass
103. Student Name	2023-09-13	92	Pass
104. Student Name	2023-09-13	65	Fail
105. Student Name	2023-09-13	88	Pass
106. Student Name	2023-09-13	70	Pass
107. Student Name	2023-09-13	80	Pass
108. Student Name	2023-09-13	75	Pass
109. Student Name	2023-09-13	82	Pass
110. Student Name	2023-09-13	79	Pass



Бага боловсролд нийт 5 сурагч үе тэнгийн сурагчидтайгаа өөрийн чадвараа хөгжүүлэн нийгэмшин суралцаж багш нар нь тусгай дасгал даалгавар ажиллуулан хөгжүүлж байна.

ЭЕШ-ын ЭРЧИМЖҮҮЛСЭН СУРГАЛТ.
1 дүгээр сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш Н.Алтанчимэг Монгол хэл хичээлийн ЭЕШ-ын эрчимжүүлсэн сургалтыг зохион байгуулав. Сургалтад 12 дугаар ангийн 21 сурагч, сонгон судлахын 12 сурагч хамрагдлаа.

ЗОРИЛТ-6:


Сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багшийн мэргэжлийн үндэсний цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

- *Үндсэн сургалт – 1 жил -5 багш, 10 дахь жил 1 багш*
- *APLUS сургалт, ажлын байрандаа хөгжих*
- *Мэргэжлийн зэрэгтэй багш нарын сургалт*
- *Багш, сурагч солилцоо хөтөлбөр*
- *Ахмадаасаа суралцъя үйл ажиллагаа*
- *Ур чадварын уралдаан*
- *Залуу багш манлайлал бүсийн үйл ажиллагаа*

МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГТЭЙ БАГШ НАРЫН ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭЛТ

Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжихэд тэргүүлэх, заах аргач зэрэгтэй багш нарын оролцоо, манлайллыг нэмэгдүүлж, сургалтын чанар үр дүнд бодитой ахиц гаргах залуу багш нартаа мэдлэг мэдээлэл олгох зорилготой ЗЭРЭГТЭЙ БАГШИЙН МАНЛАЙЛАЛ сургалтыг 2 удаа зохион байгууллаа. Тэргүүлэх зэрэгтэй 9, заах аргач зэрэгтэй 5 багш сургалтыг зохион байгуулж, 24 багш, удирдах ажилтан, 150 гаруй эцэг, эх асран хамгаалагч нар хамрагдав.


III Бүсийн ЕБС-иудын хамтын ажиллагааны хүрээнд 2 дахь удаа зохион байгуулсан "БАГШ, СУРАГЧ СОЛИЛЦОО-2024" багш, ахлах ангийн сурагчдын дундах үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Дашбалбар сумын ЕБС-ийн газарзүйн багш С.Батзориг болон 10-11-р ангийн 4 сурагч Халхгол сумын ЕБС-ийн сургалт үйл ажиллагаанд хамрагдаж туршлага судлаж ирсэн. "ХОЛ ОЙР ХИЛ ЗААГААС ҮЛ ХАМААРАН ХАМТДАА ХӨГЖЬЕ"




Багш нар ажлын байрандаа үйлийнхээ явцад ээлжит хичээлийн хөтөлбөрөө сайжруулах замаар аргазүйгээ нэмэгдүүлж, тасралтгүй хөгжлийг дэмжин "ШИЛДЭГ АРГА ЗҮЙТЭЙ БАГШ" шалгаруулах зорилготой УР ЧАДВАР-2024 уралдаан зохион байгуулагдаж, нийт 26 багш хичээл заан өрсөлдсөн.

“APLUS” СУРГАЛТ

Тус сургалтад манай 28 багш, удирдлагаас 26 хүн хамрагдсан буюу нийт багшийн 93 хувь нь хамрагдаж 100 хувь нь 2 сургалтад амжилттай батламж авсан. Тэтгэврийн 2 багш хамрагдаагүй.



Амжилт 3.0 нэгдсэн системтэй гэрээг сунган байгуулж энэ хичээлийн жилд ашигласан. Мэргэжлийн хичээлүүд, даалгаварууд багш бүр ашиглах боломжтой, орон зай, цаг хугацааг хэмнэсэн. Мөн багш нараас гадна эцэг эх, суралцагч, удирдлагуудыг хөгжүүлэлт хийгдсэн. Боловсролын салбарын мэдээллийн esis.edu.mn шууд холбож, 17 бүлгийн дэвшилт 5 бүлгийн төгсөлт хийгдлээ.



АХМАДААС СУРАЛЦЬЯ-3 ХӨТӨЛБӨРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ахмад багш, ажилтан нарын арга туршлагаас суралцах, хойч ирээдүй болсон суралцагчдад сургамж, зөвлөгөө авах, залуу багш ажилтан нар үлгэр дуурайлал авахад оршино гэсэн зорилготойгоор сургуулийн ахмадын зөвлөл нь 2023.09.26-30-ны өдрүүдэд сургуультай хамтран ажиллах төлөвлөгөө гарган ажилласан. Багш бүрийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх, уулзалт, сургалтад 30 гаруй багш, 23 ажилтан, 140 гаруй сурагчид оролцож ахмад багш ажилчдын зөвлөмж, зөвлөгөөг сонсов.


Ахмадын баярыг угтан багш, ажилтаны дунд хөгжөөнд уралдаан зохион байгууллаа. Нийт 20 гаруй ахмад багш, ажилтан оролцов. Монгол наадгай болох шагай шүүрэх, шагай таалцах, шагай няслах гэсэн гурван төрөл дээр тэмцээн амжилттай үргэлжилсэн.



Үр дүн: Ахмадаас суралцах, сурагч, багш, ажилтан нарт мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч, цаашид хамтран ажиллахад олон шинэлэг саналуудыг дэвшүүлсэн. Түүний нэг бол эцэг, эх, асран хамгаалагч нарт сургалтуудыг хамтдран хэрэгжүүлэх болсон.

Сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилсан багшийн мэргэжлийн үндэсний цахим системийг ашиглан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, үр чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох

2023-2024 хичээлийн жилд БШУГ-ын судлагдахууны мэргэжлийн хөгжлийн бүлэгт нийт 29 багш, 3 удирдах ажилтан, нийгмийн ажилтан, дотуур байрны 2 багш 130 гаруй арга хэмжээ үйл ажиллагаанд ороцоож, орон зай үл хамааран хамтдаа суралцсан.



ЗОРИЛТ-8:

Суралцагч бүр орон зай, цаг хугацаанаас үл хамааран MEDLE.MN сургалтын үндэсний нэгдсэн платформыг ашиглан суралцах тэгш боломж бүрдүүлэх

Тус сургуулийн 10,11 дүгээр ангийн 37 сурагч тус бүр 4 хичээлийг сонгон суралцаж байна. Мэргэжлийн багш нар платформуос өөрсдийн судлагдахууны дагуу хичээл сургалтандаа ашиглах материалыг татан авч сурагчдадаа ашиглуулж байна.

Medlee.mn 4 дүгээр ангийн Математикийн 1 хичээл, 11 ангийн Монгол хэлний 1 хичээл байршуулсан.

Medlee.mn сургалтын нэгдсэн платформыг судлан математикийн 6-12 дугаар цахим хичээлүүдийг үзэж, тэмдэглэл хөтлөн, түүнийгээ сурагчдад түгээн дэлгэрүүлэн хичээл сургалтад ашиглаж байна. Сургуулийн дата ашиглан суралцагч бүр орон зай цаг хугацаанаас үл хамааран сургалтыг нэгдсэн платформыг ашиглан хичээлийг гүнзгийрүүлэн үзэх боломж бүрдсэн. Amjilt.com цахим журналд ангийн бүртгэл судалгаа тэмдэглэлийг оруулж хичээлийг шинэлэг маягаар хөтөлбөрийн дагуу зааж байна. Ухаалаг самбар дэлгэцтэй, шинэ ширээ сандалтай болсоноор ангийн сурах суралцах орчин таатай болсон нь хүүхдүүд ангидаа ихэнх цагыг үр дүнтэй өнгөрөөхөд зарцуулдаг болсон. **Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурын дагуу 87 даалгавар боловсруулан ахицыг тооцож ажилласан.**

ЗОРИЛТ-9:

Дотуур байрны орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хамгаалах, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш ажилтан, эцэг эх асран хамгаалагчид тулгуурлан хэрэгжүүлэх

2023-2024 хичээлийн жилд дотуур байранд 1-12 дугаар ангийн 86 малчин өрхийн 120 хүүхэд ая тухтай орчинд суралцаж байна. Хичээлийн жилийн хугацаанд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 5 зорилтын хүрээнд 31 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлсэн.



Үүнд: 1-5 дугаар ангийн сурагчдын гэрийн даалгаварыг тогтмол хийлгэж, номын санчтай хамтран явуулын номын санг ажиллуулсан. Нийт 180 гаруй ном тахимаар уншсан байна.



2 долоо хоногт 1 удаа амралтын өдрөөр эрүүл мэндийн цаг буюу чөлөөт цагаар спорт зааланд тоглодог. Нийт 28 удаа спорт тоглоомоор тоглосон.


✓ Намар, хаврын улиралд өглөө 06 цагт босож гүйж дасгал хөдөлгөөн 30 гаруй удаа хийсэн.



7 хоног бүрийн 3 дахь өдөр -Сургалт нөлөөлийн цагт: Сургуулийн захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, мэргэжлийн багш, номын санч, эмч нартай хамтран 38 удаагийн сургалт нөлөөлийн ажил, мөн хүүхдийн насанд тохирсон видео кино 16 удаа үзүүлсэн.



Улиралд бүр хоолны амт чанарын судалгааг авч хоолны чанарыг сайжруулан ажилладаг. 4 удаагийн давамжтай авч сурагчдаас гарсан санал хоол үйлчилгээнд сайжруулан ажилласан.



Үр дүн: Дотуур байрны эцэг, эх, асран хамгаалагчдын тайлант өдөрлөг 3 удаа зохион байгуулсанаар багш, сурагч, эцэг эхийн гурвалсан холбоо сайжирч, дотуур байрны орчинг сайжруулах, сурагчдын чөлөөт цаг зөв боловсон өнгөрүүлэхэд нийт 6,0 сая төгрөгийн тохилог орчин бүрдүүлэхэд үнэтэй хувь нэмэр, дэмжлэг болсон.

ЗОРИЛТ-10:

Дотуур байрны орчинд аливаа хэлбэрийн гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, эрсдэлийг бууруулах, хянах, үнэлэх зэрэг үйлчилгээ үзүүлэх чиглэлээр хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх

Дотуур байранд ажиллах 1 өдөр хөтөлбөрт үйл ажиллагаанд Дотуур байрны 120 сурагчдад АУБ нар БАГШ АЙЛЧЛАЛ арга хэмжээг зохион тулгамдаж буй асуудалд зөвлөгөө мэдээлэл өгөх, сурагчдын хоцрогдлыг арилгахад хамтран ажилласан.

Хүүхдийг үүсч болзошгүй эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга замууд, энэ төрлийн гэмт хэргийг мэдээлэх, тусламж үйлчилгээ авах арга хэрэгсэлийн талаар мэдээлэл өгөх, өсвөр насны хүүхэд, эцэг эх, асран хамгаалагчдын ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилготой “Чи ганцаараа биш” аяныг сумын нийгмийн ажилтантай хамтран 1-12 дугаар эцэг эх асран хамгаалагчид, 9-10 дугаар ангийн сурагчдад сургалт зохион байгуулалаа. Сургалтад 61 эцэг эх, асран хамгаалагч, 76 сурагч хамрагдав. Мөн аяны хүрээнд ирүүлсэн постер, контентыг сургуулийн пейж хуудсанд байршуулан бусадд түгээн дэлгэрүүлэн ажиллав. Цахим хандалтын тоо- 329 хүнд хүрсэн байна.

Үе тэнгийн дээрэлхэлтийн хэлбэр түүний үр дагаврыг танин мэдэх сурагчид бие биенийгээ уриалах болон ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилготой сарын аяныг зохион байгуулсан. Сарын аяны хүрээнд хийгдсэн дээрэлхэл дэлгэрэх ёсгүй постер, бичлэгийг сургуулийн пейж хуудас болон багш ажилтан өөрийн бүр цахим хуудсанд нийтэлж түгээн дэлгэрүүлэв. Цахим хандалтын тоо- 2418 хүнд хүрсэн байна. Мөн 3-12-р ангийн 18 бүлгийн 396 сурагчид хамрагдсан.



Үр дүн: Үйл ажиллагаануудыг зохион байгуулснаар сурагчдын идэвх оролцоо нэмэгдэж, бие биенээсээ суралцах чадвар нэмэгдсэн. СӨУБ-ын сурагчдын тоо нэмэгдсэн.



ЗОРИЛТ-11:

Онцгой байдлын үед суралцагч өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэг, ур чадвараа хэрэгжүүлэх дадлага, сургуулилыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах

Дадлага сургуулилт 2 удаа зохион байгуулсан.
/Намар, Хавар/



2023 оны 09 сард зохион байгуулсан Улсын онцгой байдлын газар болон Дорнод аймгийн онцгой байдлын газраас Дашбалбар сумын гамшгийн бэлэн байдлын бэлтгэл сургуулилыг цагийн байдал газар хөдлөлтийн гамшгийн үеийн бэлэн байдлаар зохион байгуулсан. Авран эрэн хайх бүлгийн багт С.Сайнбат, Г.Баатармөнх, Х.Мөнгөнхуяг, Б.Базар, Ганбат нар орж ажилласан. Дадлага сургуулилтад давхардсан тоогоор **600 гаруй сурагч, 50 гаруй багш**, ажилтан нар хамрагдав. Сургалтыг сургалтын менежер Т.Ганчимэг удирдан зохион байгуулав.

2024 оны 04 дүгээр сард зохион байгуулсан дадлага сургуулилтад бага, дунд, ахлах ангийн **580 гаруй сурагчид, 30 гаруй багш ажилчид** хамрагдав. Сургалтаар газар хөдлөлтийн талаар анхан шатны мэдлэгтэй болсон.

4 дүгээр сарын 12-ны өдөр сургуулийн 27 багш, 24 ажилчид, 1-12 дугаар ангийн 418 сурагчдад насан туршийн боловсролын багштай хамтран газар хөдлөлтийн талаарх сургалт зохион байгуулав. Мөн сурагчдын зөвлөлийн 21 сурагчидтай хамтран сургуулийн гадаад дотоод орчны үнэлгээг хийн засан сайжруулах ажлын төлөвлөгөөг гарган ажилласан.



ЗОРИЛТ-12:

Сургуулийн номын сангийн үйлчилгээг сурах, сургах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн сурч хөгжих, төлөвших, хамтран ажиллах, мэдээлэл авахад нь туслах орчин болгон өөрчилж, үйлчилгээний нээлттэй байдлыг хангах

Энэ хичээлийн жилд сурах бичиг хангалт:

- ✓ Бага ангийн 10 бүлэг 301 сурагчдад, 2158 ширхэг сурах бичиг олгосон, хангалт 100 хувь
- ✓ Дунд анги 8 бүлэг 227 сурагчдад, 3629 ширхэг сурах бичиг олгосон, хангалт 94-100 хувь
- ✓ Ахлах анги 4 бүлэг 94 сурагчдад, 1039 ширхэг сурах бичиг олгосон, хангалт 80-95 хувь

Түрээсийн сурах бичиг 46 багц олгон Пос төхөөрөмжөөр уншиж, 1,003,200 төгрөгийг төвлөрүүлсэн.



- Дотуур байрны хүүхэд хөгжлийн танхимд уншлагын булан
- Бага сургуулийн давтлага өрөөнд номын булан
- Сургуулийн гадна байгалийн номын сан

**Бага
ангийн
дэмжих
төсөл**

Номын сангийн уншлага үйлчилгээг тогтмол танхимаар зохион явуулж байнгын уншигчийн карттай 295, үүнээс өдөр тутмын уншигч 86, танхимаар болон картаар 1454 ширхэг номуудыг олгож үйлчилсэн байна.

Номын сангийн төлөвлөгөөт ажлын дагуу уншигчдынхаа дунд түүхэн тэмдэглэлт өдрүүдээр сургуулийнхаа ЗАН-үүдтэй хамтран соёл хүмүүжлийн ажлуудыг зохион явуулдаг. Үндэсний номын баяраар хөтөлбөрт арга хэмжээ зохион явуулж “Тэргүүний уншигч” нараа шалгаруулж урамшуулав.

Мөн сурагчдын дунд танин мэдэхүйн уралдаан, багш, иргэдийн дунд Монгол бичгийн хичээнгүй бичиг, уншлага зохион явуулж аваргуудыг шалгаруулав. Уншлагын танхимдаа “Тоглонгоо суралцъя” шатар, даам байршуулан хүүхдүүд тоглох явцдаа номоо уншиж судлах, анги, хамт олноороо хамтран тоглох нөхцөл бүрдүүлж, сурагчдыг номын санд сууж сургах талд анхааран ажилласан.

Дотуур байр, бага ангийн сурагчдад нүүдлийн номын үйлчилгээ- 3 удаа, Алтан хонх – 1 удаа, Үсэглэлийн хаад- 1 удаа, АХА- 3 удаа, Чанга уншлага- 3 удаа, Шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн- 12 удаа

2024-2025 оны хичээлийн жилийн сурах бичиг захирлын тушаалаар байгулагдсан ажлын хэсэг хүлээн авч бүртгэлжүүлсэн





Багшийн нийгмийн асуудлыг дэмжих:

- ❖ Сумын төсвийн хөрөнгөөр дутагдалтай байгаа боловсон хүчин дэмжих зорилгоор Сүхбаатар аймгаас ирж 3 дахь жилдээ ажиллаж буй бага ангийн багшид дэмжлэг үзүүлж, Улз хороололд **2 өрөө орон сууцаар** хангасан.
- ❖ 2024 онд ашиглалтад орох сумын төрийн албан хаагчдын орон сууцжуулах хөтөлбөрт – **3 багш** хамрагдана.
- ❖ Ногоон байр буюу Багш, ажилчдын байранд бусад хот, аймаг, сумаас зорин ирж ажиллаж буй **5 багшийг** орон сууцаар үнэ төлбөргүй байрлуулж, сургууль туслах аж ахуйгаас идэшний дэмжлэг үзүүлсэн.

Завхан аймаг- Бага ангийн багш гэр бүлийн хамт

Баяндун сум - Бага ангийн багш

Дархан-Уул аймаг - Газарзүйн багш

Дорнод аймаг – Физикийн багш

Увс аймаг – Сургалтын менежер



Оюутны дэмжлэг хөтөлбөрт

- ❖ Дорнод аймгийн “Нутгийн ирээдүй” хөтөлбөрт бага ангийн багш 1
- ❖ Сумын “Хүний хөгжил” хөтөлбөрт 5 оюутан суралцаж байгаагийн бага ангийн багш 3, физикийн багш 1, хоол зүйч 1 хамрагдаж байна.

**Бага ангийн багш - 3 /2 эчнээ, 1 өдрөөр/
Физикийн багш -1 /МУБИС - 3 курс/
Хоол зүйч -1 /1 жил мэргэшүүлэх/**



Дашбалбар сумын оюутан
залуучуудын холбоо



Багш, сурагчдыг урамшуулах хөтөлбөр


2024 оны өсвөр үеийн Жүдо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнд амжилт үзүүлсэн мөнгө, хүрэл медаль хүртсэн 2 сурагч, бэлтгэсэн багш Х.Мөнгөнхуяг, УАШ хамтлаг бүжгийн тэмцээнд Тэргүүн байр эзэлсэн 1 сурагч, УАШ өсвөр үеийн хөнгөн атлетикийн тэмцээн 200м гүйлт мөнгөн медаль хүртсэн 1 сурагч бэлтгэсэн багш С.Сайнбат нарт сумын Засаг даргын 2022 оын 05 дугаар сарын 27-ны өдрийн А/117 тоот тушаалаар “Багш, сурагчдыг урамшуулах хөтөлбөр”-өөс **1,200,000** төгрөгийн урамшуулал олгогдсон.

Сургалтын орчин сайжруулах

БШУЯ-ны захиалгаар Эрдэнэ үйлдвэрийн хөрөнгө оруулалтаар Бага сургуулийн ариун цэврийн байгууламжийн засварын ажлыг “Ажнай шарга” ХХК 73,0 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.

2023 оны Орон нутийн сангийн хөрөнгөөр Бага сургуулийн хэсэгчилсэн засварын ажлыг “Донж өргөө” ХХК 290,0 гаруй сая төгрөгийн төсөвт өртгөөр хийж гүйцэтгэн хүлээлгэн өгөхөд бэлэн болж, бага сургуулийн 310 гаруй сурагч, багш, ажилтан нар нь ая тухтай, тохилог дулаан орчинд суралцах, ажиллах нөхцөл бүрдсэн.

- ✓ Бага сургуулийн хэсэгчилсэн засвар 250,0 сая
- ✓ ЖУДО бөхийн дэвжээ 20,0 сая
- ✓ Дотуур байрны дотор камержуулалт - 5,0 сая
- ✓ Багш, ажилтаны байрны халаалтын бүрэн засвар-38,3 сая
- ✓ Нэгдсэн халаалталт – 180,9 сая
- ✓ Итгэлтэй утас



2024 оны Дорнод аймаг, сумын **Орон Нутгийн Хөгжлийн Сангийн** хөрөнгө оруулалтаар хийж хэрэгжүүлэх төсөвт ажлууд.

Сургууль:

- 2.6 Сургууль, цэцэрлэг бүсийг байгуулах, цэцэрлэгт хүрээлэн тохижуулах – 218,1 сая төгрөг

- 2.7 ЕБС-ийн багш нарыг компьютержуулах

/аймаг 50%, сум 50%/ - 55,0 сая төгрөг

- 2.8 Сургуулийн сурагчийн ширээ, сандал – 41,1 сая төгрөг /аймаг 50%, сум 50%/



Дорнод аймаг, сумын ОНХСангийн хөрөнгөөр **75,1 сая** төгрөгийн төсөвт өртгөөр СУРАГЧИЙН ШИРЭЭ, САНДАЛ багцаараа 239 ширхэг буюу бага сургуулийн 4 анги, дунд сургуулийн 11 ангид хуваарилагдаж, нийт 15 анги бүлэг нь сурагчийн ширээ сандалтай болсноор шинэ ширээ сандалтай 100 хувь боллоо.

Мөн багшийн ширээ 19 кабинетад шинэчлэгдсэн.



Аймгийн Засаг даргын санаачилгаар хэрэгжүүлсэн төслийн хүрээнд аймгийн төсвийн хөрөнгөөр **9,4 сая** төгрөгний төсөвт өртөгтэй Бага сургууль нь “Багш хөгжлийн төв”- тэй болсон. Багш нар хэрэгцээ, ажлын шаардлагад нийцсэн иж бүрэн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг хүлээлгэн өгсөн.

Үр дүн: Багш нар нь ажлын байрандаа тасралтгүй хөгжих, ая тухтай орчинд ажилласнаар, сурах, сургах үйлд зүйн арга, ур чадвар сайжирч, сургалтын чанарт нөлөөлөх бодит хөрөнгө оруулалт болсон.

Дорнод аймаг, сумын ОНХСангийн хөрөнгөөр **26,4 сая** төгрөгийн төсөвт өртгөөр БАГШ КОМПЬЮТЕР багш бүрт зөөврийн компьютержуулах ажлыг хэрэгжүүлж байгаа бөгөөд эхний 10 багш нь компьютерийг хүлээн авсан.

УГТАХ ОРЧИН ТОХИЖУУЛАХ

Угтах орчин сайжруулах зорилготой хичээлийн 2 байрны үүдний хэсгийн тохижуулах ажлыг гэрээ байгуулан **11,6 сая** төгрөгний төсөвт өртөгтэй хийж гүйцэтгэж байна.





**АНХААРАЛ ХАНДУУЛСАН ТА БҮХЭНД
БАЯРЛАЛАА.**